



2021 оны 11 дүгээр сарын 12  
№42 /1192/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠲᠦ᠋ᠷᠢᠶᠢᠨ  
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠢᠨ  
ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |      |  |  |      |
|------|--|--|------|
| 375. | Гамшгаас хамгаалах тухай хуульд<br>нэмэлт, өөрчлөлт оруулах тухай  |  | 3079 |
| 376. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай<br>хуульд өөрчлөлт оруулах тухай |  | 3081 |
| 377. | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай<br>хуульд нэмэлт оруулах тухай     |  | 3082 |

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |      |   |           |      |
|------|---|-----------|------|
| 378. | Үндсэн хуулийн цэцийн 2021 оны<br>07 дугаар дүгнэлтийн тухай    | Дугаар 80 | 3083 |
| 379. | Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүнд<br>өөрчлөлт оруулах тухай | Дугаар 81 | 3084 |

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- |      |   |            |      |
|------|---|------------|------|
| 380. | Тогтоолд нэмэлт оруулж,<br>журам батлах тухай | Дугаар 140 | 3085 |
| 381. | Техникийн зохицуулалт батлах тухай            | Дугаар 148 | 3087 |

### МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

- |      |  |           |      |
|------|--|-----------|------|
| 382. | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай<br>хуулийн 33.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг<br>Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох<br>заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан<br>шийдвэрлэсэн тухай | Дугаар 07 | 3100 |
|------|--|-----------|------|

385'	Тойргалзас Тэжэв Мөрдөдөгс I Күлэс Зийгөвчлэгдэс Досгел З дагвал Кээгит Имардогой Фолио_ оя Фойгогзос Нөөл I яс Нойрвөгөөдө нидгйгдэ ги Тэжэв I яс Кээгит Күлэс Зийгөвчлэгдэс Досгел Нөөл I яс ЗЗ' З гэдгэ* 1018 оя Имардогой Фолио_ оя Фойгогзос Нөөл I яс Сүсэ I яс гойрмалгдэ	гэдгэ* 01	3100
381'	Дундуйт оя Токрөөдөлгйгдэ гйрөгөөдө Досгел Досгөдгөд гдө Имардгдэ Фолдодло' гио, гйрөгөөдө Досгел Имардогой Фолио_ оя Тэжэв ( оя Гэггэ* оя Досгөдгөдгө	гэдгэ* 148 гэдгэ* 140	3081 3082
380'	Фолдодгөөдө Досгел Күлэс О Фелгэ I яс Дөгү Нольдэс О Билгдгдэс гдө Фойрлэгдгйгдэ Фойгогзос Нөөл I яс Сүсэ I яс ЗОЗ1 Фос О О1 гэдгэ* гойрмалгдэ I яс Досгел Имардогой Фолио_ оя Ягкдэ Нольдэс оя Досгөдгөдгө	гэдгэ* 81 гэдгэ* 80	3084 3083
311'	Зийк I яс Зийгөвчлэгдэс Күлэс Нөөл I гдө Имардгдэ Фолдодгөөдө Досгел Имардогой Фолио_ оя Ягкдэ Нольдэс I яс Досгел Нөөл I гдө Фойрлэгдгйгдэс Фолдодгөөдө Досгел Гэвчлэг ( Фос Нөөлдгдэгдгөөдө Досгел Нөөл I гдө Имардгдэ' Фойрлэгдгйгдэс Фолдодгөөдө Досгел Имардогой Фолио_ оя Нөөл I		3085 3081 3010

**ᠵᠢᠨᠰᠠᠮᠤ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 10 дугаар  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 50.11 дэх хэсэг нэмсүгэй:

“50.11. Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа онцгой байдлын байгууллагын алба хаагчид таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгоно.”

**2 дугаар зүйл.** Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.12 дахь хэсгийн “нэмэгдэл,” гэсний дараа “мөнгөн урамшуулал,” гэж нэмж, мөн хэсгийн “50.11-д” гэснийг “50.11, 50.12-т” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн “50.11, 50.12, 50.13” дахь хэсгийн дугаарыг “50.12, 50.13, 50.14” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

АКЦИН ХАНАГАХ АХУЙН Т

ЗО, [БЭЭГЭЭРИЙГЭ\*] Т

ШОЯДОРГО ФОНД ОЯ

4 дугаар талбар. Хүснэгт III 11 ЗОЗЗ Хоорондоо Ой дугаар 26-т 119 Ой - 0 Фүдэг, Хүснэгт IV-ийн Дотоод Шилжилтийг.

2008-11-20, 15-20, 13-20, 14-20»-ийн Дотоод Шилжилтийг.

3 дугаар талбар. Хүснэгт I (Хүснэгтийн Дотоод Шилжилтийн 20-дугаар талбар орон 20-11, 20-15, 20-13)»-ийн Хүснэгт орон

«Шилжилтийн Хүснэгтийн»-ийн Хүснэгт орон «20-11 - 20-15»-ийн Хүснэгт I «20-11, 20-15 - 20»-ийн Хүснэгтийг.

5 дугаар талбар. Хүснэгт I (Хүснэгтийн Дотоод Шилжилтийн 20-дугаар талбар орон 20-15 дугаар талбар орон «Шилжилтийг»-ийн Хүснэгт I

Талбар»)»

Энд орон шилжилтийн Тийш Шилжилтийн Хүснэгт дотор, 20-дугаар талбар орон 20-28-т 119 Хүснэгтээс Сэлбэгийн Дотоод Шилжилтийн Хүснэгтийн Хүснэгт орон шилжилтийн 20-дугаар талбар орон 20-28-т 119 Хүснэгтээс Сэлбэгийн Дотоод Шилжилтийн Хүснэгтийг. Тийш Шилжилтийн Хүснэгт орон шилжилтийн 20-дугаар талбар орон 20-28-т 119 Хүснэгтээс Сэлбэгийн Дотоод Шилжилтийн Хүснэгтийг. Тийш Шилжилтийн Хүснэгт орон шилжилтийн 20-дугаар талбар орон 20-28-т 119 Хүснэгтээс Сэлбэгийн Дотоод Шилжилтийн Хүснэгтийг.

Хүснэгт нэмэгдэл :

1 дугаар талбар. Хүснэгт I (Хүснэгтийн Дотоод Шилжилтийн 20-дугаар талбар орон 20-28-т 119 Хүснэгтээс Сэлбэгийн Дотоод Шилжилтийн Хүснэгтийг)

Шилжилтийн Хүснэгтийн Хүснэгтийн Дотоод Шилжилтийн Хүснэгт

Хүснэгт I (Хүснэгтийн Дотоод Шилжилтийн Хүснэгтийн 20-дугаар талбар орон

2021 Хоорондоо Ой дугаар 26-т 119 ЗО - орон Фүдэг

Хүснэгтээр өөрчлөгдсөн

ШОЯДОРГО ФОНД ОЯ ШИЛЖИЛТИЙН



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 10 дугаар  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 18 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2021 оны 11 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Улсын Ерөнхийлөгч (Эрх Засагт)  
МОНГОЛ УЛСЫН  
ГЗ

Эрх Засагт Ерөнхийлөгч.

Улсын Ерөнхийлөгч. Энэ хуулийг 2021 оны 11 дүгээр сарын 05 -

2021 оны 10 сарын 29-ний өдөр

1 дүгээр зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12

МОНГОЛ УЛСЫН

МОНГОЛ УЛСЫН

2021 оны 10 дугаар сарын 29 - өдөр  
МОНГОЛ УЛСЫН

МОНГОЛ УЛСЫН



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 10 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 80

Улаанбаатар  
хот

### Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 07 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.2.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хэргийг прокурорт буцаасан шийдвэрийг прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан эсэргүүцэл бичих, гомдол гаргах эрхтэй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “... шударга шүүхээр шүүллэх, ... эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж тус тус заасныг зөрчсөн байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 07 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

### Г.ЗАНДАНШАТАР

ҮКҮГ НОЛЫГ 09 ДЭЛ0) 1      60'    [66962109\* 1  
ИМОНДОГ ҮО10\_ 09

Киiлiйэ тоiрзiлiлэсэжiи.  
Ү09 0 10 00бi \* 26\* 1 119 50 - 0 Ү00\* 09 02 00бi \* 001000000 11  
Тоiлсэжэсэ рiлiлi \* Кэсэ Ү0100209 Н001 119 Сэсэ 119 5051  
Үiлхэс 0 рiр Ү000 1 Н01000000 \* Кi0 00\_ 00\_ 11дөөсэсэ 1  
Н001 101 119 \* р000) 1 1 Вiлiр00КК \* \* КК4КҮ 11  
Кэiлi 09 « 0010 Үсэ Кишэ 0 Ү4КҮ Ү4КҮ С110КҮ 11 Н000000000 \* \* \*  
21ККК \* \* \* Ү4КҮ 001 \* \* \* \* Ү4рiрэ 112000К \* 1000 09 1 0КҮН  
11д00000 \* 1000 09 1 4 0КҮН 11д0000 119 « \* \* \* 2100000 21ККК рiс  
Кишэ Вiлi Н001 1 21КК 119 Ү000 1 Ү4КҮ 0КҮ 1 рiлiлi \* \* Ү4рiрэ  
Кэiлi 09 « ИМОНДОГ ҮО10\_ 00 Н001 1020 рiс Ү00219 2000) 1  
Ү010\_ 09 Ү0100209 Н001 119 Ү4рiрэ 00100000 \* 1000 09 1 0КҮН  
рiсiК' Г000000 00дөөс0 Ү4КҮ 001 \* \* Кi0 11дөөсэсэ Ү00 ИМОНДОГ  
Киiлiйэ Ү4рiрэсэ Үсэ Н0021 Ү0110 09 2 Ү00 \* 00 рiрiрiрiрэ ҮсэiКсэж  
10209 0 001000000 \* Ү000000000 Үсэ 10120100000 Ү0( 2100Вiл 11  
Вс0дөөсэсэ 2100Вiл 11 000 110 \* 1010000000000 \* 0КҮ 0 Н001 1  
33' 3 00бi \* 1000 09 5 0КҮН Кэiлi 00 « Кэiлi 1 000 110 \* 00  
1' « Ү4КК0 119 Кэiлi 0000 2100Вiлiлiк 0000 1 Н001 119

Ү0100209 ИМОНДОГ ҮО10\_ 09 ҮКҮГ НОЛЫГ Үсэ 000000000 Ү00 :  
Dif 09 Д0001 Н001 119 85 00бi \* 1000 09 85' 5' 3 0КҮН 11д000 11  
ИМОНДОГ ҮО10\_ 09 ҮКҮГ НОЛЫГ 09 С1000000 0 Н00100000 0

02 00бi \* 001000000 119 Д0001  
Ү0100209 Н001 119 Сэсэ 119 5051 Ү09 0  
00бi \* 80      Ү0100000000 \* Н000  
5051 Ү09 0 10 00бi \* 26\* 1 119 58 - 0 Ү00\*

ИМОНДОГ ҮО10\_ 09 ҮКҮГ НОЛЫГ 09 Д00000000





## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 10 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 81

Улаанбаатар  
хот

### Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Жамъянхорлоогийн Сүхбаатарыг Хүний эрхийн дэд хорооны гишүүнээр баталсугай.

2.Энэ тогтоолыг 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

ҮКҮҖ НОЛҮҖ 09 Дьёло) Т GO' [өөрөгсгидэ\* Т  
Шорьдог Үолго\_ 09

Үрр\* Үсэ Үкүгэс Дьдө)0 шорьдогсүкүгү.

С' Үлэ Дөөгөсдөгү 1 С0С1 Ү09 0 10 гөдө\* 26\* Т 119 С8 - 0

гүгөгсөдөгү.

201күрүдөгү\* 1 Күшэ 0 Үкүгү 119 Дьдү Нолүсэ 0 Күгүкү 116\*

1' Шорьдог Үолго\_ 09 Үкүгү Нолүг 09 Күгүкү 116\* 119 С8 - 0

Дөөгөсдөгү Үолго :

С0' 3 гүкү Күгүт 1 Үолгөс02019 Шорьдог Үолго\_ 09 Үкүгү Нолүг Үсэ  
Сидордэс 0 Нолүг02019 0 Дийт 09 Дөөгү Нюл 1 119 С0 гөдө\* 1018 09  
1018 09 8' 1' 0 гүкү 116)19 ' Шорьдог Үолго\_ 09 Үкүгү Нолүг 09  
Шорьдог Үолго\_ 09 Үкүгү Нолүг 09 Дөөгү Нюл 1 119 8 гөдө\*

Үолгүсгүгүгү Үолдодгөө Дөөгү

Күшэ 0 Үкүгү 119 Дьдү Нолүсэ 0 Виллүкү 90

гөдө\* 81 Үолгөсгүгүгү\* Ногс

С0С1 Ү09 0 10 гөдө\* 26\* 1 119 С8 - 0 Үрр\*

Шорьдог Үолго\_ 09 Үкүгү Нолүг 09 Дөөгөсдөгү

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 5 дугаар  
сарын 12-ны өдөр

Дугаар 140

Улаанбаатар  
хот

### Тогтоолд нэмэлт оруулж, журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 57.2.4, 57.8-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа төрийн үйлчилгээний зарим албан хаагчид хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгох журам”-ыг Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 8 дугаар хавсралт болгон хавсралт ёсоор баталсугай.

2. “Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дэх заалтын “7 дугаар” гэсний дараа “хавсралт, “Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа төрийн үйлчилгээний зарим албан хаагчид хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгох журам”-ыг 8 дугаар” гэж нэмсүгэй.

3. Энэ тогтоол гарсантай холбогдон гарах нэмэлт зардлыг 2021 оны батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэх, цаашид жил бүр зохих журмын дагуу төсвийн төсөлд тусгаж санхүүжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Л.ОЮУН-ЭРДЭНЭ**

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД**

**А.АРИУНЗАЯА**



Засгийн газрын 2021 оны 140 дүгээр  
тогтоолын хавсралт

Засгийн газрын 2018 оны 382 дугаар  
тогтоолын 8 дугаар хавсралт

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН, АХМАД НАСТАНД ТУСЛАМЖ,  
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖ БАЙГАА ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРИМ  
АЛБАН ХААГЧИД ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛИЙН  
НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ**

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд сэргээн засах, хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх тусламж, үйлчилгээ, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа төрийн үйлчилгээний зарим албан хаагчид хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эмч, сувилагч, туслах сувилагч, асрагч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хэл засалч, сэтгэл засалчид тухайн ажил, албан тушаал эрхлэх хугацаанд нь албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдлийг сар бүр олгоно.

3. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ үзүүлж байгаа арга зүйч, багш, туслах багш, нийгмийн ажилтанд тухайн ажил, албан тушаал эрхлэх хугацаанд нь албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдлийг сар бүр олгоно.

4. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний төрөлжсөн асрамжийн газарт ажиллаж байгаа асрагчид тухайн ажил, албан тушаал эрхлэх хугацаанд нь албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдлийг сар бүр олгоно.

5. Хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдлийг тухайн байгууллага жил бүрийнхээ төсөвт тусгаж олгоно.



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 5 дугаар  
сарын 19-ний өдөр

Дугаар 148

Улаанбаатар  
хот

### Техникийн зохицуулалт батлах тухай

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 6.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Агаарын чанарын техникийн зохицуулалтыг 1 дүгээр хавсралт, усны чанарын техникийн зохицуулалтыг 2 дугаар хавсралт, хөрсний чанарын техникийн зохицуулалтыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Техникийн зохицуулалтын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Т.Гантулга)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолыг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Л.ОЮУН-ЭРДЭНЭ**

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

**Н.УРТНАСАН**

Засгийн газрын 2021 оны 148 дугаар  
тогтоолын 1 дүгээр хавсралт

### АГААР ЧАНАРЫН ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Нэгдүгээр бүлэг

Ерөнхий зүйл

#### 1.1.Зорилго, хамрах хүрээ

1.1.1.Энэ техникийн зохицуулалт нь хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор агаарын чанарыг хянах, үнэлэх, агаарын бохирдлын эх үүсвэрт тавих шаардлагыг тогтооход оршино.

1.1.2.Энэ техникийн зохицуулалтыг агаарын бохирдлын суурин болон хөдөлгөөнт эх үүсвэр ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээд заавал дагаж мөрдөнө.

## 1.2.Норматив эшлэл

Энэ техникийн зохицуулалтад эш татаж хэрэглэсэн дараах стандарт, баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийг хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлээс эш татаж хэрэглэнэ.

-MNS 4585 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага.

-MNS 5885 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага.

-MNS 6298 Шинэ дулааны цахилгаан станц, дулааны станцын яндангаар агаар мандалд хаях утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга.

-MNS 5919 Дулааны цахилгаан станц, дулааны станцын уурын ба ус халаах зуухны ашиглалтын үед агаар мандалд хаях утааны найрлага дахь бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, тэдгээрийг хэмжих арга.

-MNS 5043 4.2 мВт хүчин чадалтай ус халаах зуух. Техникийн шаардлага.

-MNS 6342 Агаарын чанар. Аюултай хог хаягдал шатаах зуухны яндангаар агаар мандалд хаягдах утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ.

-MNS 5606-1 Чандарлах зуух (крематор)-ны яндангаар агаар мандалд хаягдах утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ.

-MNS 5216 Ахуйн хэрэглээний зуух. Техникийн ерөнхий шаардлага.

-MNS 5013 Бензин хөдөлгүүртэй автомашин-утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга.

-MNS 5014 Дизель хөдөлгүүртэй автомашин-утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга.

### 1.3.Нэр томьёо, тодорхойлолт

Энэ техникийн зохицуулалтад хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

1.3.1.“агаарын бохирдол” гэж Агаарын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т заасныг;

1.3.2.“агаарын чанар” гэж Агаарын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасныг;

1.3.3.“агаар бохирдуулах бодис” гэж Агаарын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д заасныг;

1.3.4.“агаарын бохирдлын эх үүсвэр” гэж Агаарын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8-д заасныг;

1.3.5.“агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр” гэж Агаарын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д заасныг;

1.3.6.“хөдөлгөөнт эх үүсвэр” гэж Агаарын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.10-т заасныг.

#### Хоёрдугаар бүлэг

#### Агаарын чанар, түүнд тавигдах шаардлага

2.1.Агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулах бодис болох PM10, PM2.5 тоосонцор, хүхэрлэг хий (SO<sub>2</sub>), азотын давхар исэл (NO<sub>2</sub>), озон (O<sub>3</sub>), нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)-н зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4585 стандартын шаардлагыг хангасан байна.

2.2.“Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4585 стандартаар зохицуулаагүй бусад агаар бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь “Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага” MNS 5885 стандартын шаардлагыг хангасан байна.

2.3.Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан агаарын чанарыг сайжруулах бүс тогтоосон тохиолдолд бүсийн журмыг мөрдөнө.

## Гуравдугаар бүлэг

### Агаарын бохирдлын эх үүсвэрт тавигдах шаардлага

3.1.Шинээр барих болон шинээр өргөтгөж байгаа дулааны цахилгаан станц ба дулааны станцад “Шинэ дулааны цахилгаан станц, дулааны станцын яндангаар агаар мандалд хаях утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга” MNS 6298 стандартын шаардлагыг хангасан зуухыг ашиглана.

3.2.Дулааны цахилгаан станц, дулааны станцуудын уурын болон ус халаах зуухны ашиглалтын явцад хэвийн нөхцөлд гарч байгаа агаар бохирдуулах бодисуудын зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь “Дулааны цахилгаан станц, дулааны станцын уурын ба ус халаах зуухны ашиглалтын үед агаар мандалд хаях утааны найрлага дахь бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, тэдгээрийг хэмжих арга” MNS 5919 стандартын шаардлагыг хангасан байна.

3.3.Нүүрс, шингэн түлш болон хийгээр ажиллах 4.2 мВт хүртэл чадалтай ус халаах зуухыг ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээд “4.2 мВт хүчин чадалтай ус халаах зуух. Техникийн шаардлага” MNS 5043 стандартын шаардлагыг хангасан халаалтын зуухыг ашиглана.

3.4.Аюултай хог хаягдал шатаах бүх төрлийн зуух нь “Агаарын чанар. Аюултай хог хаягдал шатаах зуухны яндангаар агаар мандалд хаягдах утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 6342, бүх төрлийн чандарлах зуух нь “Чандарлах зуух (крематор)-ны яндангаар агаар мандалд хаягдах утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 5606-1 стандартын шаардлагыг хангасан байна.

3.5.Гэр хорооллын айл өрх “Ахуйн хэрэглээний зуух. Техникийн ерөнхий шаардлага” MNS 5216 стандартын шаардлагыг хангасан зуухыг ахуйн хэрэглээндээ ашиглана.

3.6.Ахуйн хэрэглээний болон уур, ус халаах халаалтын зуух, чандарлах болон аюултай хог хаягдал шатаах зууханд стандартын шаардлага хангаж байгааг нотлох тохирлын үнэлгээний баталгаажилт хийлгэн, гэрчилгээ авсан байна.

3.7.Бензин хөдөлгүүртэй автотээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн утааны найрлага дахь агаар бохирдуулах бодис (СО-нүүрстөрөгчийн дутуу исэл, СН-нүүрсүстөрөгч)-ын зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь “Бензин хөдөлгүүртэй автомашин-утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга” MNS 5013 стандартын шаардлагыг хангасан байна.

3.8.Автомашин дигель хөдөлгүүрийн утааны тортогжилтын хэмжээ нь “Дигель хөдөлгүүртэй автомашин-утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга” MNS 5014 стандартын шаардлагыг хангасан байна.

### Дөрөвдүгээр бүлэг

#### Хяналт-шинжилгээ, мониторинг

4.1.Агаарын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасны дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь агаарын чанар, агаарт үзүүлэх физикийн сөрөг нөлөөллийн өөрчлөлтөд байнгын ажиглалт, хэмжилт судалгаа, шинжилгээ хийж үнэлгээ өгөх, мэдээллээр хангах зорилго бүхий агаарын чанарын хяналт-шинжилгээний улсын нэгдсэн сүлжээг зохион байгуулж ажиллуулна.

4.2.Эрүүл ахуйн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт заасны дагуу эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлж эрүүл мэндийг дэмжих, хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэсэн тандалт, судалгааг хийнэ.

4.3.Агаар бохирдуулах бодисын үзүүлэлтийг тодорхойлох хэмжилт, шинжилгээг агаарын чанарын үзүүлэлтийг тодорхойлох итгэмжлэгдсэн лаборатори хийнэ.

4.4.Агаарын бохирдлын эх үүсвэрийн хэмжилтийг агаарын чанарын үзүүлэлтийг тодорхойлох итгэмжлэгдсэн лаборатори хийнэ.

4.5.Энэ техникийн зохицуулалтын хэрэгжилтэд тавих хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт зааснаар зохицуулна.



Засгийн газрын 2021 оны 148 дугаар  
тогтоолын 2 дугаар хавсралт

## УСНЫ ЧАНАРЫН ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Нэгдүгээр бүлэг

Ерөнхий зүйл

### 1.1.Зорилго, хамрах хүрээ

1.1.1.Энэ техникийн зохицуулалт нь хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор усны чанарыг үнэлэх, бохирдлын эх үүсвэрт тавих шаардлагыг тогтооход оршино.

1.1.2.Энэ техникийн зохицуулалтыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа ус ашиглагч иргэн, хуулийн этгээд заавал дагаж мөрдөнө.

### 1.2.Норматив эшлэл

Энэ техникийн зохицуулалтад эш татаж хэрэглэсэн дараах стандарт, баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийн хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлээс эш татаж хэрэглэнэ.

-MNS 899. Унд ахуйн зориулалттай төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийг сонгох журам ба эрүүл ахуй. Техникийн шаардлага.

-MNS 4047. Усан мандал. Гадаргын усны чанарыг хянах журам.

-MNS 4586. Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага.

-MNS 0900. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ.

-MNS 4943. Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага.

-MNS 6561. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага.

-MNS 6734. Дахин ашиглах цэвэрлэсэн ус. Техникийн ерөнхий шаардлага.



-MNS ISO 16075. Цэвэрлэсэн хаягдал усыг усалгаанд ашиглах заавар.

-MNS 4079. Усны чанар. Нэр томьёо, тодорхойлолт.

-Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаал.

### 1.3.Нэр томьёо, тодорхойлолт

Энэ техникийн зохицуулалтад хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

1.3.1.“усны чанар” гэж Усны тухай хуулийн 3.1.20-т заасныг;

1.3.2.“усны чанарын стандарт” гэж Усны тухай хуулийн 3.1.21-д заасныг;

1.3.3.“бохирдуулах бодис” гэж Усны тухай хуулийн 3.1.22-т заасныг;

1.3.4. “зөвшөөрөгдөх дээд хэмжээ” гэж усны чанар нь шаардлагад нийцсэн эсэхийг тодорхойлох чанарын үзүүлэлтийн дээд хэмжээг;

1.3.5. “ундны ус” гэж хүн ам, хүнсний зориулалтаар хэрэглэх, эрүүл ахуйн шаардлага хангасан, стандартад нийцсэн усыг;

1.3.6.“хаягдал ус” гэж Усны тухай хуулийн 3.1.24-т заасныг;

1.3.7.“цэвэрлэсэн ус” гэж хүрээлэн байгаа орчинд нийлүүлэх болон дахин ашиглах зориулалтын чанарын шаардлагад нийцэх хүртэл боловсруулсан усыг;

1.3.8.“усны чанарын шалгуур” гэж усны чанарын үнэлгээний үзүүлэлтүүд буюу усны чанар аль нэг ашиглалтын шаардлагад нийцэж байгаа эсэхийг илтгэх багц үзүүлэлтүүдийг;

1.3.9.“усны чанарын хяналт-шинжилгээ” гэж усны чанарын төлөв байдлыг тогтоосон хөтөлбөрийн дагуу ажиглах, хянах, үнэлэх үйл ажиллагааг.

## Хоёрдугаар бүлэг

### Усны чанар, усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн хамгаалалтын бус, түүний дэглэм

2.1. Хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, экосистемийн тэнцлийг хангах зорилгоор усны орчин рН, жинлэгдэх бодис, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, химийн хэрэгцээт хүчилтөрөгч, азот, фосфор, бичил амь судлалын үзүүлэлт зэрэг усан орчны чанарын үзүүлэлт нь “Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага” MNS 4586 стандартын шаардлагыг хангасан байна.

2.2. Шинээр барих болон шинэчлэхээр төлөвлөж байгаа төвлөрсөн системээр түгээж, унд ахуйн зориулалтаар болон унд ахуй-үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах ус хангамжийн эх үүсвэрийг сонгоход “Унд ахуйн зориулалттай төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийг сонгох журам ба эрүүл ахуй, техникийн шаардлага” MNS 899 стандартын шаардлагыг хангасан байна.

2.3. Төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрээс (ус олборлох, нөөцлөх, чанарыг сайжруулах, түгээх, зөөвөрлөх, хадгалах) ус ашиглагч, хэрэглэгч хүртэлх ус хангамжийн сүлжээний үе шат бүрд хүн амын ундны болон ахуйн зориулалтаар ус хэрэглэх тохиолдолд “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900 стандартын шаардлагыг хангасан байна.

## Гуравдугаар бүлэг

### Усны бохирдлын эх үүсвэр, тавигдах шаардлага

3.1. Ахуйн хэрэглээ болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэлтээс хүрээлэн байгаа орчинд нийлүүлэх тохиолдолд усны орчин рН, өнгө, цахилгаан дамжуулах чанар, жинлэгдэх бодис, нитрат, нитрит, аммони, үлдэгдэл чөлөөт хлор, хүнд металлууд, бичил амь судлалын үзүүлэлт зэрэг нь хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын дээд хэмжээ нь “Хаягдал ус. Ерөнхий шаардлага” MNS 4943 стандартын шаардлагыг хангасан байна.

3.2. Ахуйн болон үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарсан хаягдал усыг цэвэрлэж үйлдвэрлэл, үйлчилгээнд болон хүрээлэн байгаа орчныг хамгаалах чиглэлээр ашиглах тохиолдолд хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын дээд хэмжээ нь “Дахин ашиглах цэвэрлэсэн ус. Техникийн ерөнхий шаардлага” MNS 6734, усалгаанд ашиглах тохиолдолд “Цэвэрлэсэн хаягдал усыг усалгаанд ашиглах заавар” MNS ISO 16075 стандартын шаардлагыг хангасан байна.

3.3.Ахуйн болон үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарсан хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын дээд хэмжээ нь төвлөрсөн шугам сүлжээнд нийлүүлэх тохиолдолд “Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага” MNS 6561 стандартын шаардлагыг хангасан байна.

3.4.Ус ашиглагч нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулан ажиллана.

3.5.Ахуйн болон үйлдвэр, аж ахуйн нэгжийн урьдчилсан цэвэрлэх байгууламжаас гарсан лаг, хог хаягдлыг цэвэрлэх байгууламжийн лагийн талбай, аюултай хог хаягдлыг булшлах талбайгаас бусад газарт хаяхыг хориглоно.

3.6.Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмын дагуу хамгаалалтын бүсийн хилийн заагийг тогтоож Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга усны мэдээллийн санд бүртгүүлнэ.

#### Дөрөвдүгээр бүлэг

##### Хяналт-шинжилгээ, мониторинг

4.1.Усны тухай хуулийн 6.1-д заасны дагуу усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь усны нөөц, горим, чанарын төлөв байдал, өөрчлөлтөд байнгын ажиглалт, хэмжилт, судалгаа, хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, мэдээллээр хангах зорилго бүхий усны хяналт-шинжилгээний нэгдсэн сүлжээг зохион байгуулж ажиллуулна.

4.2.Эрүүл ахуйн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт заасны дагуу эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлж эрүүл мэндийг дэмжих, хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэсэн тандалт, судалгааг хийнэ.

4.3.Ус бохирдуулах бодисын үзүүлэлтийг тодорхойлох хяналт-шинжилгээг итгэмжлэгдсэн лабораторид хийнэ.

4.4.Усны бохирдлын эх үүсвэрийн хэмжилтийг итгэмжлэгдсэн лаборатори хийнэ.

4.5.Энэ техникийн зохицуулалтын хэрэгжилтэд тавих хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт зааснаар зохицуулна.

Засгийн газрын 2021 оны 148 дугаар  
тогтоолын 3 дугаар хавсралт

## ХӨРСНИЙ ЧАНАРЫН ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Нэгдүгээр бүлэг

Ерөнхий зүйл

### 1.1.Зорилго, хамрах хүрээ

1.1.1.Энэ техникийн зохицуулалтын зорилго нь хүн амын аюулгүй байдлыг хангахад хөрсний чанарыг хянах, үнэлэх, хөрсний бохирдлын эх үүсвэрт тавих шаардлагыг тогтооход оршино.

1.1.2.Энэ техникийн зохицуулалтыг Монгол Улсын нутаг дэвсгэрт хөрсний чанарт сөрөг нөлөөлөл үзүүлэхүйц үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

### 1.2.Норматив эшлэл

Энэ техникийн зохицуулалтад эш татаж хэрэглэсэн дараах стандарт, баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийг хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлээс эш татаж хэрэглэнэ.

-MNS 5850 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ.

-MNS 3297 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх.

-MNS 6147 Байгаль орчны бохирдол, бохирдлын хяналт ба хамгаалалт-Агаар, хөрсөн дэх пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ.

-MNS 6783 Ашиглалтаас гарсан хар тугалгат-хүхрийн хүчлийн батареийг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах. Ерөнхий шаардлага.

-MNS 3985 Байгаль хамгаалал. Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр төрөл.

-MNS 6501 Байгаль орчин. Арьс шир, үслэг боловсруулах үйлдвэрийн хаягдлын ерөнхий ангилал, код.

-MNS 6487 Байгаль орчин. Газрын тос боловсруулах үйлдвэрийн хаягдлын ангилал. Хаягдлын байгууламжид тавигдах шаардлага.

-MNS 5891 Азот, фосфор, калийн холимог бордоо. Техникийн шаардлага.

-MNS 4722 Шим бордоо-Чийгийн улаан хорхойн биоаялзмаг. Техникийн шаардлага.

-MNS 6265 Фосфо-гуматын холимог бордоо. Техникийн шаардлага.

-MNS 6507 Компост бордоо. Техникийн шаардлага.

-MNS 5924 Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага.

-Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаал. Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага.

-Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал. Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам.

### 1.3.Нэр томъёо, тодорхойлолт

Энэ техникийн зохицуулалтад хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

1.3.1.“хөрсний бохирдол” гэж хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бохирдуулагчийн агууламж нь хөрсөнд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн байхыг;

1.3.2.“хөрс бохирдуулах бодис” гэж хөрсөнд тогтвортой удаан хугацаагаар хадгалагддаг, амьд организмд аюултай хор нөлөө үзүүлдэг, уусах чанар багатай, хортой хүнд металлууд, удаан задардаг органик бохирдуулах бодисыг;

1.3.3.“зөвшөөрөгдөх дээд хэмжээ” гэж Эрүүл ахуйн тухай хуулийн 3.1.8-д заасныг;

1.3.4.“эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт” гэж Эрүүл ахуйн тухай хуулийн 3.1.7-д заасныг.

### Хоёрдугаар бүлэг

#### Хөрсний чанар, түүнд тавигдах шаардлага

2.1.Хөрсөнд тогтвортой удаан хугацаагаар хадгалагддаг, амьд организмд аюултай нөлөө үзүүлдэг, уусах чанар багатай, хорт хүнд металлууд, удаан задардаг органик бохирдуулах бодисуудын зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь “Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 5850 стандартын шаардлагыг хангасан байна.



2.2.Хот суурин газрын хөрсний эрүүл ахуйн байдалд тавигдах шаардлага, хөрсний эрүүл ахуйн байдал, бохирдлын түвшин нь “Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх” MNS 3297 стандартын шаардлагыг хангасан байна.

2.3.Хүрээлэн буй орчны хөрсөнд байх пестицидийн зөвшөөрөгдөх хэмжээ нь “Хөрсөн дэх пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 6147 стандартын шаардлагыг хангасан байна.

2.4.Ашиглалтаас гарсан хар тугалгат-хүхрийн хүчлийн батареийг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулахад тавих ерөнхий шаардлагыг тогтоох, үйл ажиллагаанд хяналт тавих, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хамгаалахтай холбоотой үйл ажиллагаа нь “Ашиглалтаас гарсан хар тугалгат-хүхрийн хүчлийн батареийг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах. Ерөнхий шаардлага” MNS 6783 стандартыг хангасан байна.

#### Гуравдугаар бүлэг

#### Хөрсний бохирдлын эх үүсвэрт тавигдах шаардлага

3.1.Арьс шир болон үслэг боловсруулах үйлдвэрлэлээс гарах бүх төрлийн хаягдалд тавигдах шаардлага нь “Байгаль орчин. Арьс шир, үслэг боловсруулах үйлдвэрийн хаягдлын ерөнхий ангилал, код” MNS 6501 стандартыг хангасан байна.

3.2.Газрын тос, байгалийн хий олборлох, боловсруулах үйлдвэрлэлийн хаягдлыг ангилан хадгалах, булшлах устгах ажиллагаанд “Байгаль орчин. Газрын тос боловсруулах үйлдвэрийн хаягдлын ангилал. Хаягдлын байгууламжид тавих ерөнхий шаардлага” MNS 6487 стандартыг хангасан байна.

3.3.Хөрсний ариун цэврийн байдалд заавал хийгдэх үзүүлэлтүүдийг тогтооход “Байгаль хамгаалал. Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтүүдийн нэр төрөл” MNS 3985 стандартыг мөрдөж ажиллана.

3.4.Азот, фосфор, калийн бордоог савлах, хадгалах, тээвэрлэхэд “Азот, фосфор, калийн бордоо. Техникийн шаардлага” MNS 5891 стандартыг хангасан байна.

3.5.Шим бордоо-чийгийн улаан хорхойн био ялзмагийг үйлдвэрлэх, шалгах, хадгалах, савлах, тээвэрлэхэд “Шим бордоо-чийгийн улаан хорхойн био ялзмаг, Техникийн шаардлага. Экологийн цэвэр бүтээгдэхүүн” MNS 4722 стандартыг хангасан байна.

3.6.Фосфор болон гумины хүчлийн бодисыг нэгэн зэрэг агуулсан холимог бордоог үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэхэд “Фосфо-гуматын холимог бордоо. Техникийн шаардлага” MNS 6265 стандартыг хангасан байна.

3.7.Ургамал, амьтны гаралтай органик хаягдлаар үйлдвэрлэсэн бордоо нь “Компост бордоо. Техникийн шаардлага” MNS 6507 стандартын шаардлагыг хангасан байна.

3.8.Төвлөрсөн болон бие даасан ариутгах татуургын системд холбох боломжгүй айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудын ахуйн хэрэгцээнд хэрэглэх нүхэн жорлон, угаадасны нүх нь “Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага” MNS 5924 стандартын шаардлагыг хангасан байна.

3.9.Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгахдаа Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 54/А/136/А215 дугаар тушаалаар баталсан “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах” журмыг мөрдөж ажиллана.

3.10.Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулахдаа Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/443 дугаар тушаалаар баталсан “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага” журмыг мөрдөж ажиллана.

#### Дөрөвдүгээр бүлэг

#### Хяналт-шинжилгээ, мониторинг

4.1.Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т заасны дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь байгаль орчны төлөв байдал, түүний хувьсал өөрчлөлтөд хэмжилт, шинжилгээ хийж дүгнэлт гаргах, илэрсэн сөрөг өөрчлөлтийг зогсоох, арилгах арга хэмжээ авах зорилгоор хяналт шинжилгээний нэгдсэн сүлжээг зохион байгуулж ажиллуулна.

4.2.Эрүүл ахуйн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт заасны дагуу эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлж эрүүл мэндийг дэмжих, хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэсэн тандалт, судалгааг хийнэ.



4.3. Хөрс бохирдуулах бодисын үзүүлэлтийг тодорхойлох хэмжилт, шинжилгээг итгэмжлэгдсэн лаборатори хийнэ.

4.4. Хөрсний бохирдлын эх үүсвэрийн хэмжилтийг итгэмжлэгдсэн лаборатори хийнэ.

4.5. Энэ техникийн зохицуулалтын хэрэгжилтэд тавих хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт зааснаар зохицуулна.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2021 оны 10 дугаар  
сарын 20-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар  
хот

### Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн  
хуралдааны танхим 12.20 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Б.Буяндэлгэр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Г.Туулхүү, Г.Баясгалан /илтгэгч/, Ж.Эрдэнэбулган, Д.Гангабаатар нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Э.Түмэнбаяр, Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг болон Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

**Нэг. Монгол Улсын иргэн Ц.Гансүх, Г.Батболд нар Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:**

“... Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.13 дахь заалтад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны “оролцогч” гэж сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, хуулийн этгээд, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг

ойлгохоор зохицуулсан байдаг. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж заасан. Өөрөөр хэлбэл, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, хуулийн этгээд, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч нь Монгол Улсад хууль ёсоор оршин сууж байгаа тохиолдолд эрх тэгш гэсэн үг.

Гэтэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч гомдол гаргах эрхтэй, харин хохирогч, түүний өмгөөлөгчийн гомдол гаргах эрхийг тусгаж өгөөгүй, хязгаарласан байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасантай нийцээгүй гэж үзэж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг анх батлагдахдаа хэргийг прокурорт буцаасан шийдвэрийг прокурор эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан эсэргүүцэл бичих эрхтэй гэж байсныг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар “, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч” гэж нэмэгдсэн.

Практик дээр шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийгээд хэргийг прокурорт буцаасан тохиолдолд яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч тэр бүр гомдол гаргадаггүй. Харин энэхүү шийдвэрийн улмаас хамгийн их хохирч үлддэг, хэргээ шүүхэд шилжүүлэх хүсэл сонирхолтой, эрх ашиг нь хөндөгддөг этгээд бол хохирогч байдаг. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн хэмжээг тогтоох, гаргуулах, гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах хугацаа сунжирч удааширдаг. Хохирогч, түүний өмгөөлөгчийн зүгээс хэргийг прокурорт буцаах тухай шүүгчийн захирамжийг эс зөвшөөрч, гомдол гаргасан тохиолдолд анхан шатны шүүх гомдол гаргах эрхгүй гэх үндэслэлээр гомдлыг хүлээн авахаас татгалздаг. Ер нь яллагдагч, түүний өмгөөлөгч тухайн тохиолдолд гомдол гаргах эрхтэй юм бол хохирогч, түүний өмгөөлөгч ч гэсэн гомдол гаргах эрхтэй байвал хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх Үндсэн хуулийн зорилго, зорилт хангагдана гэж үзэж байна.

Яллагдагч, түүний өмгөөлөгч, хэргийг прокурорт буцаасан шүүгчийн захирамжийг эс зөвшөөрч, гомдол гарган хэлэлцүүлдэг харин хохирогч, түүний өмгөөлөгч тухайн тохиолдолд гомдол гаргах эрхгүй, гомдлоо хэлэлцүүлж чадахгүй байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад заасан шударга шүүхээр шүүлтэх гэсэнтэй нийцээгүй гэж үзэж байна. Тиймээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хэргийг прокурорт буцаасан шийдвэрийг прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан эсэргүүцэл бичих, гомдол гаргах эрхтэй.” гэсэн нь

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн холбогдох заалтыг зөрчсөн тухай мэдээлэлд маргаан үүсгэж, Цэцийн хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэр гаргаж өгнө үү.” гэсэн байна.

**Хоёр. Монгол Улсын иргэн Э.Түмэнбаяр Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:**

“... Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хэргийг прокурорт буцаасан шийдвэрийг прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан эсэргүүцэл бичих, гомдол гаргах эрхтэй.” гэж заасан.

Эрүүгийн хэргийг анхан шатны шүүхээр хянан хэлэлцээд шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэх, шүүгдэгчид холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, шүүгдэгчийг цагаатгах, эсхүл хэргийг прокурорт буцаах шийдвэрийн аль нэгийг гаргахаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулсан. Шүүхээс гарах дээрх шийдвэрт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч гомдол гаргах боломжоор хангагдсан байх учиртай. Ялангуяа хэргийг прокурорт буцаах шийдвэрийн тухайд хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөрөг нөлөөлөл үзүүлдэг, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх боломж нь цаг хугацааны хувьд удааширдаг, хохирогчийг залхаадаг. Гэтэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хэргийг прокурорт буцаасан шийдвэрт эсэргүүцэл бичих, гомдол гаргах эрх зөвхөн прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид олгогдсон байх бөгөөд хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч хэргийг прокурорт буцааж буй шүүхийн шийдвэр болох шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргах эрхийг хуулиар хязгаарласан гэж үзэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. ...” талаар хуульчилсан. Үндсэн хуулиар олгогдсон дээрх эрхийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хязгаарлаж буй нь Үндсэн хуулийн дээрх заалттай нийцэхгүй байна. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасантай нийцэхгүй байна. Учир нь төр хүний эрхийн баталгааг хангах, хүний эрхийн

зөрчилтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах үүрэгтэй байтал зөрчигдсэн эрхээ хамгаалуулах боломжийг нь ердийн хуулиар хязгаарласан нь Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулж байна гэж үзэж байна.

Нөгөө талаас эрүүгийн хэргийн бусад оролцогчид болох яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, прокурорт хэргийг буцаах тухай шүүхийн шийдвэрт гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрхийг олгосон атлаа хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид энэхүү эрхийг олгоогүй нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн эсэхийг маргаан үүсгэн хянан шийдвэрлэж өгнө үү.” гэсэн байна.

***Гурав. Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:***

“... 1.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” болон Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.” гэснийг зөрчөөгүй байна. Учир нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6.2 дахь заалтад “хохилогчийн хууль ёсны төлөөлөгчийг томилох, өөрчлөх талаарх санал, хүсэлт;” гаргах нь нээлттэй байгаа учраас хохирогч түүний хууль ёсны төлөөлөгч оролцох эрх нь хангагдаж байна.

2.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... шударга шүүхээр шүүлгэх ...” гэснийг зөрчөөгүй. Учир нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлд заасан шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд энэ нь хэрэгжиж буй бөгөөд буцаасан тохиолдолд хохирогч, түүний өмгөөлөгчийн эрхийг хөндөхгүй, эцсийн шийдвэр биш юм. Иймд шударга шүүхээр шүүлгэх болон хохирогч, түүний өмгөөлөгч нь гомдол гаргах эрхийг хязгаарлаагүй, харин нээлттэй юм.

3.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө



хариуцна.” гэсэн нь гэмт хэргийн зүйлчлэлд яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн эрхийг хөнддөг учраас эсэргүүцэл бичих, гомдол гаргах эрхийг нээх мөн гэм буруугүй шийдвэрт хохирогчийн эрх хөндөгдөх учраас аль аль нь шүүхэд гомдол, эсэргүүцэл бичих эрхээр хангагдаж байна.

Иймд Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хэргийг прокурорт буцаасан шийдвэрийг прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан эсэргүүцэл бичих, гомдол гаргах эрхтэй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй гэж үзэж байна.” гэжээ.

***Дөрөв. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:***

“... Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 1 дүгээр зүйлд “Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. ...”, 7 дугаар зүйлд “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчилалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. ...” гэж тус тус заасан.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон харьяалалдаа байгаа бүх хүний энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй.” мөн Пактын 26 дугаар зүйлд “Бүх хүн хуулийн өмнө тэгш байх бөгөөд аливаа алагчилалгүйгээр хуулиар тэгш хамгаалуулах эрхтэй. Энэ үүднээс аливаа байдлаар алагчилах явдлыг хуулиар хориглох бөгөөд хууль нь арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн байдал буюу бусад байдлаар алагчилахаас бүх хүнийг адил тэгш үр нөлөөтэй хамгаалах баталгааг бүрдүүлэх ёстой.” гэжээ.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн гэрээний хороодын Ерөнхий зөвлөмж нь гэрээний зүйл, заалтыг тайлбарласан албан ёсны эх сурвалж юм. Тухайлбал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Хорооны 1989 оны 18 дугаар Ерөнхий зөвлөмжийн 1-д “үл ялгаварлан гадуурхах, хуулийн өмнө эрх тэгш байх болон аливаа ялгаварлан гадуурхалтгүй ижил хэмжээний хуулийн хамгаалалтад байх нь хүний эрхийн хамгаалах суурь ба ерөнхий зарчим юм.” гээд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын дээрх заалтууд нь хуулиар ижил хамгаалуулах эрхийг бүх хүмүүст олгоод зогсохгүй, хуулиар ялгаварлан гадуурхахаас хамгаалах талаар тайлбарласан байна.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй. ...” гэж зааснаас үзэхэд хүн бүр шүүн таслах ажиллагааны явцад, хуулийг хэрэглэж байгаа аргын хувьд ч ялгаварлан гадуурхагдах ёсгүй байна. Түүнчлэн эрх тэгш байх нь шүүхийн өмнөх болоод шүүх хурлын бүхий л шатанд хангагдсан байх ёстой бөгөөд энэ нь хүн бүр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хуулиар ялгаварлан гадуурхагдахгүй байх, хүн бүр эрхээ сэргээлгэхийн тулд шүүхэд адил тэгш хандах эрхтэй байх ёстой.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. ...” гэж заасан.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхагдахгүйгээр, хуулийн этгээд бүр хөрөнгө, орлого, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын хэлбэрээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж заасан. Мөн хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.13 дахь заалтад “оролцогч” гэж сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, хуулийн этгээд, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг ойлгохоор томъёолсон байх ба уг хуулийн 15.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн уг ажиллагааны оролцогч, бусад оролцогч, хуулийн этгээд нь шүүх, прокурор, мөрдөгчийн шийдвэр, ажиллагаанд гомдол гаргах эрхтэй гэж оролцогчдын гомдол гаргах эрхийг баталгаажуулсан ч мөн хуулийн 33.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хэргийг прокурорт буцаасан шийдвэрийг прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан эсэргүүцэл бичих, гомдол гаргах эрхтэй.” гэж заасан нь хохирогчийн гомдол гаргах эрхийг орхигдуулж, хүн бүр шударга шүүхээр шүүлгэх, шүүхийн шийдвэрт давж заалдах, хохирлоо нөхөн төлүүлэх зэрэг эрхүүд хязгаарлагдах нөхцөлийг бүрдүүлсэн гэж үзэхээр байна.

Иймд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, дотоодын хууль тогтоомжид хууль шүүхийн өмнө хүн бүр тэгш байх зарчмыг тусгасан байх ба эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн оролцогч болох хохирогчийн гомдол гаргах эрхийг тус ажиллагааны бүхий л шатанд баталгаажуулах нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад нэн ач холбогдолтой юм.” гэсэн байна.



## ҮНДЭСЛЭЛ:

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Гучин гуравдугаар бүлэгт яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, шүүх хуралдааны бэлтгэл хангах ажиллагааны журмыг хуульчилсан байх бөгөөд мөн бүлгийн 33.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үед хуульд заасан үндэслэлээр шүүх өөрийн санаачилгаар, эсхүл хэргийг буцаах тухай прокурорын санал, яллагдагч, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан хэргийг прокурорт буцаах асуудлыг шийдвэрлэхээр зааж, тухайн ажиллагааны тэгш эрх бүхий талуудыг тодорхой нэрлэн заажээ.

Харин мөн хуулийн 33.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хэргийг прокурорт буцаасан шийдвэрийг прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан эсэргүүцэл бичих, гомдол гаргах эрхтэй.” гэж заасан байна. Ийнхүү шүүхийн дээрх шийдвэрийг эс зөвшөөрвөл зөвхөн яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч гомдол гаргах эрхтэй байхад тухайн ажиллагааны оролцогч тал болох хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн гомдол гаргах эрхийг хязгаарлаж, орхигдуулан хуульчилсан нь хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд харшилж байна.

2.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад тусгасан “шударга шүүхээр шүүлгэх эрх”-ийн хүрээ нь олон улсын эрх зүйд хүлээн зөвшөөрөгдсөн “шударгаар шүүлгэх эрх”-ийн агуулгатай дүйцэж байгаа бөгөөд шүүхийн өмнөх, түүнчлэн шүүх хуралдааны болон түүний дараах үе шатанд эдлэх цогц эрхийг илэрхийлсэн өргөн агуулгатай ойлголт болно. Тухайлбал, хуулийн дагуу байгуулагдсан, бүрэн эрх бүхий, алагчлалгүй шүүхээр хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэх эрх төдий бус, шүүх хуралдаанаас өмнө эрх зүйн туслалцаа авах, өмгөөлөгчөө сонгох, ялласан, баривчилсан үндэслэлийг мэдэх, эрүү шүүлтэд өртөхгүй байх, хүнлэг нөхцөлд хоригдох, хэргийг цаг алдалгүй шийдвэрлүүлэх, нотлох баримт шалгуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд талууд эрх тэгш байж, тэгш боломжоор хангагдах, ялгаварлан гадуурхлаас ангид байх зэрэг нь дээрх эрхийн хүрээнд багтаж байна.

Үүнээс үзэхэд, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад заасан хүний шударга шүүхээр шүүлгэх эрхийг зөрчсөн шинжтэй байна.

3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу хэргийг прокурорт буцаасан шүүхийн шийдвэр нь тухайн хэргийг бүхэлд нь хянан хэлэлцэж гаргасан шийдвэр бус, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд гаргаж буй явцын буюу завсрын шинжтэй шийдвэр тул тус зохицуулалт нь Үндсэн хуулиар баталгаажсан шүүхийн

шийдвэрийг давж заалдах эрхийг хязгаарласан гэж үзэх үндэслэлгүй байна. Тодруулбал, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрх нь тухайн эрх зүйн маргааныг хянан хэлэлцээд эцэслэн шийдвэрлэж гаргасан шүүхийн шийдвэрт хамаарах ойлголт бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын (талуудын) хууль ёсны ашиг сонирхлыг хангахад чиглэгдсэн завсрын шинжтэй шийдвэрт гомдол гаргах нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад заасан шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхийг шууд хөндөхгүй болно. Энэ талаар Үндсэн хуулийн цэц 2007 онд 09 дүгээр дүгнэлт, 2020 онд 07 дугаар дүгнэлт тус тус гаргасныг тэмдэглэх нь зүйтэй.

4.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцахаар заасан. Гэтэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн зохицуулалтаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарим оролцогчийн эрхийг үндэслэлгүйгээр хязгаарласан байна.

5.Нэгдсэн Үндэстний Байгууллагаас баталсан Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 7 дугаар зүйлд “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчилалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. ...” гэж, Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 26 дугаар зүйлд “Бүх хүн хуулийн өмнө тэгш байх бөгөөд аливаа алагчлалгүйгээр хуулиар тэгш хамгаалуулах эрхтэй. Энэ үүднээс аливаа байдлаар алагчилах явдлыг хуулиар хориглох бөгөөд хууль нь арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн байдал буюу бусад байдлаар алагчилахаас бүх хүнийг адил тэгш, үр нөлөөтэй хамгаалах баталгааг бүрдүүлэх ёстой.” гэж тус тус заасан болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

### **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ НЬ:**

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хэргийг прокурорт буцаасан шийдвэрийг прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан эсэргүүцэл бичих, гомдол гаргах эрхтэй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “... шударга шүүхээр шүүллэх, ... эрхтэй. ...”, Арван



есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж тус тус заасныг зөрчсөн байна.

2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “... шүүхийн шийдвэрийг давж заалдах, ... эрхтэй. ...” гэснийг зөрчөөгүй байна.

3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хэргийг прокурорт буцаасан шийдвэрийг прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан эсэргүүцэл бичих, гомдол гаргах эрхтэй.” гэж заасныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ**

**ГИШҮҮД**

**Б.БУЯНДЭЛГЭР**

**Г.ТУУЛХҮҮ**

**Г.БАЯСГАЛАН**

**Ж.ЭРДЭНЭБУЛГАН**

**Д.ГАНГАБААТАР**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turiin\_medelel@parliament.mn

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 2

**Индекс: 200003**